



БАЯНХОНГОР АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/04

Эмзэгтэй

Сум, орон нутгийн хэмжээнд өвөл, хаврын  
морины уралдааныг хориглох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Эрүүгийн хуулийн 16.10 дугаар зүйлийн 1, Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 3.3, Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны А/12 дугаар захирамж, Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн 2025 оны 01 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөл, хаврын улиралд зохион байгуулах үсэргээ, сунгаа, уралдааны үеэр хүүхэд мориноосоо унах, осгох, унасан морь халтирч хүүхэд дарагдах зэрэг хүүхдийн эрүүл мэндэд ноцтой хохирол учруулахуйц аюултай нөхцөл байдал үүсэж болзошгүй тул хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээг жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд хориглосугай.

2.Сум, багийн нутаг дэвсгэрт хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаа зохион байгуулахгүй байхыг “Молор эрдэнэ” морин спорт уяачдын холбоо, нийт уяачид, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Хууль, тогтоомж, зөвлөмж болон уралдааны үеэр гарч болох эрсдэлийг малчин иргэд, эцэг эх, хурдан морь унаач хүүхэд, уяачдад сурталчлан таниулж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Баяржаргал), Ерөнхий боловсролын сургуулийн захирал (М.Болор-эрдэнэ), Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан (О.Мөнхжаргал), Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан (Г.Нарангэрэл), Нийгмийн эрүүл мэндийн ажилтан (О.Болорцэцэг), Хэсгийн төлөөлөгч (Б.Амарзаяа), нарт тус тус үүрэг болгосугай.

642501278

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Түмэнжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Б.САРАНЦЭЦЭГ